



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 1112

Сэвхүүл

Цол олгох тухай

Монгол Улсын "Үндэсний их баяр наадмын тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, сумын болон бэсрэг наадмуудад хурдан морьдоо уяж уралдуулан Аймгийн наадмаас нэг түрүү, гурван айраг, сумын наадмаас гурван түрүү, таван айраг, бэсрэг наадмуудаас есөн айраг авсан Лувсандоржийн Амаржаргал, Аймгийн наадмаас 2 айраг, сумын наадмаас нэг түрүү, хоёр айраг, бэсрэг наадмуудаас таван айраг авсан Чимэддоржийн Баттогтох нарт сумын "Алдарт уяач", мал сүргээ жил бүр дундаас дээш тарга хүч авхуулан, төлөөр нь өсгөн үржүүлж, үүлдэрлэг байдал болон эрүүл мэндийг анхаарч мал эмнэлгийн ажил үйлчилгээг технологит хугацаанд нь чанартай хийлгэж, цөөн малтай болон залуу малчдыг малжуулахаар авч байгаа арга хэмжээ, орон нутагт оруулж байгаа хувь нэмэр, малч ухаан, хөдөлмөр зүтгэл, ажилсаг чанарыг үнэлж Батсүхийн Отгонбаатарт сумын "Сайн малчин" цол олгосугай.

2. Сумын Засаг даргын зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн сумын цол олгох ажлыг зохион байгуулахыг сумын Засаг даргын орлогч /Ж.Цэвээндулам/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



В БАТ-ЭРДЭНЭ